

**АВЛИГАТАЙ ГАЗРЫН ЗӨВЛӨМЖИЙН ХҮРЭЭНД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ
1/713 ДУГААР АЛБАН БИЧГЭЭР ЗӨМЛӨМЖ, ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

2023.12.05

“Бумбат”

Авлигатай тэмцэх газраас тус аймагт хийсэн хяналт, шалгалттай холбогдуулан дараахь ажлуудыг сум, байгууллагынхаа түвшинд хийж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Зөвлөмж 1. Мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтныг мэргэшүүлж, тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч, тэднээс эрх, үүргээ хэрэгжүүлэхэд байгууллагын удирдлагын зүгээс дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангаж ажиллах.

Авлигын эсрэг хуулийн дагуу манай суманд мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтан нь ЗДТГ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга нар байна. Эдгээр албан тушаалтныг тогтвор суурьшилтай ажиллахад ажиллах нөхцөл нийгмийн баталгааг бүрэн ханган ажиллаж байна. Эрх бүхий албан тушаалтнууд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах ажлыг хуулийн хугацаанд зохион байгуулж нэг албан хаагчийн мэдүүлгийг орхихгүй арга зүй, зөвлөмжөөр хангаж хэвшээд байна.

Зөвлөмж 2. Нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж бичгээр мэдэгдэх, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл бичгээр тайлбар гаргаж хэвшүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.

Нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцдаа болон ажлын хэсэг, үнэлгээний хороонд орж ажиллахдаа ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдал үүссэн даруй эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэж, мэдэгдэл тайлбараа гаргаж ирүүлж байх талаар заавар, зөвлөмж өгч арга зүйгээр ханган ажиллаж хэвшээд байна. Энэ хугацаанд үнэлгээний хороонд 1 албан хаагч ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл байдал үүссэн даруй мэдэгдэж арга зүйн зөвлөгөө авч худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооноос татгалзах мэдэгдэл хүргүүлсэн. Худалдан авах ажиллагаатай холбоотой мэдэгдэл, тайлбарыг тухай бүр хянаж, ашиг сонирхлын зөрчил эрсдэлээс урьчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байна.

Мөн Ажил хүлээлцэх ажлын хэсгийн захирамжид Эхнэр нөхөр 2 нэг ажлын хэсэгт дарга гишүүнээр оруулахаар нэрсийг нь төлөвлөсөн байсан тул урьдчилан мэдэж, дараа нь гарах сөрөг үр дүгаварыг тайлбар таниулж гишүүдийг өөрчлүүлэн шийдвэрийг гаргасан байна.

Зөвлөмж 3. Нийтийн албан тушаалд томилогдсоноос хойш хуульд заасан хугацаанд Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг /ХАСХОМ/ гаргаж

хэвшүүлэх, хугацаандаа гаргаагүй албан тушаалтанд хариуцлага тооцож байх, түүнд тавих хяналтыг сайжруулах.

Нийтийн албан тушаалд томилдсоноос хойш 30 хоногийн дотор тухайн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулах талаар заавар зөвлөгөө өгч хэвшээд байна. Энэ онд ХАСХОМ гаргах албан тушаалтан томилогдоогүй байна. хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаатнуудад анхааруулан ажиллаж байна.

Зөвлөмж 4. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүй томилдог, томилсны дараа хянуулдаг зөрчлийг таслан зогсоох.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийг төрийн үйлчилгээний болон улс төрийн удирдах албан тушаалтан шууд томилон ажиллуулах хүсэлтэй байдаг учир, сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвийн эрхлэгч, Засаг дарга нарт хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг заавал хянуулж ирсэний дараа томилох талаар тусгайлан сургалт, мэдээлэл өгч хэвшүүлсэн байна.

Зөвлөмж 5. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хандив авахтай холбоотой хязгаарлалтыг чанд мөрдөж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль зөрчин хандив авч буй үйлдлийг нэг мөр таслан зогсоох, хандивлагчтай холбоотой шийдвэр гаргахгүй байх.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хандив авахтай холбоотой хязгаарлалтыг мөрдөн ажиллаж байна. Энэ онд ЗДТГ-т иргэний танхимд ширээ хандивласан байдлыг бүртгэн авч хуулийн дагуу 2 жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой гэрээ, шийдвэр гаргахгүй байна. Мөн бусад байгууллага, албан тушаалтангуудад хууль зөрчин хандив авч эрсдэлд орохгүй байх талаар зөвлөгөө зөвлөмжийг хүргэн ажилласан байна.

Зөвлөмж 6. Худалдан авах чиглэлээр мэргэшсэн ажилтан, иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг олон давтамжтай хамруулахгүй байх, ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх.

Сумын хэмжээнд 17 албан хаагч, иргэний төлөөл 2 нийт 19 иргэн төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу АЗ сертификат үнэлгээний хороонд томилогдон ажиллаж байна. Эдгээр албан тушаалтанд авлига, ашиг сонирхлын зөрчлийн хор уршиг, эрсдэлийг сурталчилан таниулах ажлыг тухай бүр хийж байна.

Зөвлөмж 7.Тендерт оролцогчдын эрхийг зөрчих, бусдад давуу байдал үүсгэх, тендерийг нэр төдий зохион байгуулж байгаад дүгнэлт хийх, хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх.

Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд ажиллаж байгаа албан хаагчид иргэний төлөөллөөс баталгааг тогтмол авч хэвшсэн байна. Орон нутгийн худалдан авах ажиллагаанд гүйцэтгэгч буюу тендерт оролцогчид ховор, олон удаа зарласны эцэст тендер шалгаруулалт зохион байгуулагддаг нь цаг хугацаа их авдаг хүндрэлтэй байна.

Зөвлөмж 8.Засаг даргын нөөц хөрөнгийг үрэлгэн, зориулалт бусаар зарцуулж байгаад дүгнэлт хийж, төсвийн сахилга батыг чангатгах, ялангуяа баяр ёслол, тэмцээн, уралдаан, наадам, шагнал, урамшуулал, дайллага, хүндэтгэл үзүүлэх, хайрхан тайх, буцалтгүй тусламж олгох зэрэг арга хэмжээнд уг хөрөнгийг зарцуулахгүй байх.

Сумын Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмыг баримтлан хөрөнгийг зарцуулж, сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулагдаж байгаа хөрөнгийн ажлын төлөвлөгөөний дагуу гүйлгээг хийж хэвшээд байна.

Зөвлөмж 09.Орон нутагт төрийн алба, төрийн жинхэнэ албан хаагчийг улс төрийн намын нөлөөллөөс ангид, хараат бусаар ажиллах нөхцөл бүрдүүлэх, Төрийн албаны тухай хууль болон бусад хууль, тогтоомжоор хориглосон хориглолт, хязгаарлалтыг зөрчихгүй байх.

Төрийн жинхэнэ албан хаагчийг хуулиар хүлээсэн нийтлэг үүрэг, нийтлэг эрхээ хэрэгжүүлж ажиллах нөхцөлийг бүрдүүлэн, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар сургалтыг 1 удаа, ёс зүйн хорооны сургалтыг 2 удаа хийж, төрийн жинхэнэ албан хаагч ёс зүй хэм хэмжээнд баригдаж төрийн албан үүргээ хэрэгжүүлэхдээ иргэн бүрт тэгш хүртээмжтэй, шуурхай, чин шударгаар хийхийг зөвлөн таниулах ажлыг тогтмол хийж, хяналтыг тавин ажиллаж байна.

Зөвлөмж 11.Төсвийн хэтрэлт, хэмнэлт, үр ашигтай байдлыг нарийвчлан тооцож, шаардлагагүй зардлыг тэвчих, "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн хэрэгжилтийг төрийн бүх шатны байгууллага, нэгжийн түвшинд хангуулан ажиллахад анхаарах, түүнд тавих хяналтыг сайжруулах.

Төсвийн тухай хууль,Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдон гарсан тогтоол, эрхзүйн актуудаар төрийн бүх шатны байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудад мэдээлэл хүргэж, хяналтыг хийж ажиллаж байна. Санхүү албанаас төсвийн сахилга, төсвийн тухай хуулийн сургалт мэдээллийг хүргэн ажиллаж байна.

ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТИЙГ БИЧСЭН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



Д.СОНИНБАЯР